



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/02

Сүхбаатар сум

Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны
28 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 30 дугаар зүйлийн 30.1.17, Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 7 дугаар зүйлийн 7.3, Засгийн газрын 2018 оны "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай" 50 дугаар тогтоолын 3.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны "Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх тухай" 154 дүгээр тогтоолын 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 28 жилийн ойг аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлж, Монгол Улсын Үндсэн хуулийг сурталчлан, тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулсугай.

2. Сум орон нутагтаа ажиллаж амьдарч байгаа Монгол Улсын Үндсэн хууль батлалцсан Ардын Их Хурлын депутатууд болон ар гэрт нь хүндэтгэл үзүүлэх, санал хүсэлтийг нь хүлээн авч шийдвэрлэх, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг иргэд, олон нийтэд тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний тайланг 2020 оны 01 дүгээр сарын 17-ны дотор гарган аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Б.НАРАНТУЯА

C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

430801028